

## 2008 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

**01.11** Монгол Улс, Норвегийн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой болов. Уг ойг тохиолдуулан Монгол Улсын Гадаад хэргийн сайд С.Оюун, Норвегийн Гадаад хэргийн сайд ноён Ё.Г.Сторе нар илгээлт солилцон харилцан баяр хүргэв. Гадаад хэргийн сайд С.Оюун илгээлтэдээ “Монгол Улсад өрнөсөн ардчилсан шинэчлэлийг эхнээс нь тууштай дэмжиж ирсэнд Норвегийн Засгийн газарт талархалаа илэрхийлж, цаашид ардчилсан парламентад ёсыг бэхжүүлэх, байгалийн баялгаас олж буй орлогыг улс орны хөгжилд зохистой чиглүүлэх талаар туршлага судлах, энэ чиглэлийн мэргэжилтнүүд сургах асуудлаар Монгол, Норвегийн хооронд идэвхтэй хамтран ажиллах боломжтой” хэмээн дурджээ.

**01.17** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Турк улсын Анталия хотод Монгол Улсыг төлөөлөн суудаг Өргөмжит консул ноён Омер Айдинерийг хүлээн авч уулзав. С.Баяр уулзалтын эхэнд Монгол, Турк бол буурал түүхээрээ холбогдолтой ах дүү үндэстнүүд. Тиймээс бидэнд өнгөрснөө дурсаж одоо, ирээдүйд хамтран зүтгэх, хамтран амжилтад хүрэх олон салбар, өргөн боломж байна. Анталия хотын аялал жуулчлалын үнэт туршлагаас суралцаж, Монгол Улсад энэ салбарыг хөгжүүлэх бололцоо бий. Туркийн талын хөрөнгө оруулалт, туршлагатай менежерүүдийн туршлагаас суралцах зүйл бидэнд их гэж тэмдэглэв. Ноён О.Айдинер, “Бид хамтын ажиллагааны хэд хэдэн санал боловсруулж ирлээ. Барилга, эрчим хүч, аялал жуулчлалын салбарт бид илүү анхаарч байгаа. Мөн Улаанбаатар хотын орчимд усан цахилгаан станц байгуулах судалгаа хийж байна. Агаарын бохирдлыг багасгах чиглэлээр өөрсдийн саналаа дэвшүүлэх бодолтой байна. Монгол Улсын хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтад гар бие оролцож, жижиг бизнесийг дэмжих зорилготой байна” гэв.

**01.17** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Я.Ичихашиг хүлээн авч уулзав. Ноён Элчин сайд тулгамдаж буй олон асуудлыг идэвхтэй, дайчин шуурхай шийдвэрлэж, богино хугацаанд ихийг хийх зорилго тэмүүлэлтэй ажиллаж байгаад нь Ерөнхий сайд С.Баяр, түүний тэргүүлсэн Засгийн газарт баяр хүргэв. Тэрбээр Монгол Улсын Засгийн газраас тавьсан хүсэлтийн дагуу Улаанбаатарт олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих хөнгөлөлттэй зээлийн асуудлыг Японы Засгийн газар нааштай шийдвэрлэж байгааг Ерөнхий сайдад мэдээлэв. Япон улс төмөр зам, Үү цахилгаан станцын шинэчлэл гэх мэт 9 удаагийн төсөлд 39.1 тэрбум иенийн зээл тусламж үзүүлж байсныг ноён Элчин сайд энэ үеэр онцлов. Японы Засгийн газрын энэ шийдвэрт талархаж байгаагаа С.Баяр илэрхийлээд хоёр орны харилцаа ойрын 10 жилийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу амжилттай үргэлжилж байгааг тэмдэглэв. Шинэ нисэх буудал барих төсөл Японы дэлхийд тэргүүлэх техник, технологи Монголд орж ирэх, түүнээс монголчууд суралцах сайхан боломж олгох болно гэж

тэрбээр онцлоод гэрээнд гарын үсэг зурах ажлыг хойшлуулалгүй шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийлэв. Түүнчлэн Монгол Улсад төслийн бүс 800.0 сая иенийн буцалтгүй тусламж олгох баримт бичигт хоёр тал гарын үсэг зурахад бэлэн болсныг мэдээллэв.

**01.23** Монгол Улс, ИБУИНВУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой болов. Энэхүү түүхэн ойг Улаанбаатар, Лондонд харилцан тэмдэглэн өнгөрүүлэв. Британийн Парламентын ордонд болсон уг арга хэмжээний үеэр Парламент дахь Монголын бүлгийн дарга Ж.Гроган, ГХХНЯ-ны Азийн бүс нутаг хариуцсан сайд лорд М.Маллок-Браун, элчин сайд Д.Даваасамбуу, Монголчуудын холбооны гүйцэтгэх захирал Ч.Оюун нар харилцааны ач холбогдлыг үнэлэн үг хэлжээ. Британийн Парламентын хэд хэдэн гишүүн, ГХХНЯ болон холбогдох байгууллагуудын албаны хүмүүс, манай улсад элчин сайдаар ажиллаж байсан зарим хүн, монголч эрдэмтэд, Британид оршин суугаа монгол иргэдийн төлөөлөгчид зэрэг 250 орчим хүн уригдан оролцжээ.

**02.20** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр БНЭУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ё.Вармаг хүлээн авч уулзав. Удаан жилийн түүхтэй Монгол, Энэтхэгийн харилцаа сүүлийн үед боловсрол, соёлын салбарт улам үр дүнтэй хөгжиж буйд сэтгэл хангуулан байгаагаа Ерөнхий сайд илэрхийллээ. Тэрбээр, 2007 он хоёр орны харилцаанд шинэ зүйлийг бий болгосон жил болсон бөгөөд батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарт ахиц, өөрчлөлтийг авчирсан. Цаашид худалдаа, эдийн засгийн салбарт улам эрчимтэй харилцааг бий болгох, Энэтхэгийн Засгийн газраас Монгол Улсад олгохоор шийдвэрлэсэн зээлийн хэмжээ, нөхцлийн талаар тохирох, зайны сургалт, зайны оношилгооны төсөл хэрэгжүүлэх зарим ажил удааширч байгааг хоёр тал анхаарах хэрэгтэй байна гэж хэллээ. Ноён Ё.Варма дээрх асуудлыг нааштай шийдвэрлэхэд анхаарах болно гэдгээ илэрхийлээд Энэтхэг улс уул уурхай, төмөрлөгийн салбарт Монгол Улстай хамтран ажиллах боломж бий гэв.

**03.04** Монгол Улсын Гадаад хэргийн сайд С.Оюун Япон улсын Засгийн газрын урилгаар тус улсад айлчлав. Тэрээр Япон улсын Гадаад хэргийн сайд М.Комуратай албан ёсны хэлэлцээ хийв. Хоёр орны Гадаад хэргийн сайд нар Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатарын орчимд олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих тухай төслийн Ноот бичигт гарын үсэг зурав. Гадаад хэргийн сайд нар иж бүрэн түншлэлийн түвшинд хөгжиж буй хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, түүний дотор эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх талаар санал солилцов.

**03.20** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр ОХУ-ын Төрийн Думын Гадаад бодлогын байнгын хорооны дарга К.И.Косачев тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр хоёр орны харилцаа,

хамтын ажиллагааны одоо ба ирээдүйн асуудлаар санал солилцов. Ерөнхий сайд, Монгол орны эдийн засагт уул уурхай, ашигт малтмалаас олж буй эерэг сайн талууд их байгаа ч лицензийг хавтгайруулан олгосноос үүдсэн зөрчил дутагдал арилахгүй байгаа тухай ярилаа. Мөн өнө эртний харилцаатай Монгол, Орос хамтын ажиллагааны цар хүрээ илүү өргөн салбарыг хамран өргөжин тэлэх боломж байгааг тэмдэглэв. Ноён К.И.Косачев, манай хоёр орны харилцан хамтын ажиллагааны хөгжилд Ерөнхий сайд С.Баяр таны ОХУ-д хийх айлчлал их хувь нэмэр болно гэж бид үзэж байгаа хэмээв.

**04.07** Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны ээлжит хэлэлцээ Бонн хотноо амжилттай болж өндөрлөв. Хоёр тал өнгөрсөн онд хийсэн зөвлөлдөх уулзалтын үр дүнг үндэслэн, одоо хэрэгжүүлж буй болон цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагаа, чухал ач холбогдол бүхий бусад асуудлын талаар хэлэлцлээ. 1992 оноос эхэлсэн хоёр талын Техникийн болон Санхүүгийн хамтын ажиллагааны нийт санхүүжилт 244.7 сая евро болсон байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар энэхүү хэлэлцээний дагуу хоёр талын Техникийн болон Санхүүгийн хамтын ажиллагаанд зориулж 2008-2009 онд Монгол Улсын Засгийн газарт шинээр 18,5 сая евро олгохоор болов. Үүнээс гадна биологийн төрөл зүйлийг хамгаалах болон цаг уурын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,0 сая евро нэмж олгохоор болжээ. Нийт 20,5 сая еврогийн 9,0 сая еврог Санхүүгийн хамтын ажиллагааны төслүүдэд, 11,5 сая еврог (нэмж олгож буй 2,0 сая еврог оруулаад) Техникийн хамтын ажиллагааны төслүүдэд олгоно. Мөн өмнөх жилүүдэд хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээс үлдсэн 3,2 сая еврог Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд шинэ төслүүдэд зарцуулна. Ийнхүү Техникийн болон Санхүүгийн хамтын ажиллагаанд нийт 23,725 сая Еврог зарцуулахаар хоёр тал тохиролцсон байна.

**04.11** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Түүнийг дагалдан ГХ-ийн сайд С.Оюун, ҮХ-ны сайд Х.Наранхүү, Зам тээврийн сайд Р.Раш, ХХАА-н сайд Ц.Ганхуяг, ОХУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Хангай, мөн ажлын хэсэг, хамгаалалт үйлчилгээ, хэвлэл мэдээллийнхэн гэсэн 40 орчим албаны хүмүүс дагалдан явав. Ерөнхий сайд ба ажлын хэсгийнхний уулзалт Орос-Монголын ЗГХК-ын Оросын хэсгийн дарга А.В.Гордеевтай уулзсанаар эхэлж, Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр ОХУ-ын Засгийн газрын дарга В.Л.Зубковтой ганцаарчилсан уулзалт хийсний дараа Ерөнхий сайд С.Баяр ОХУ-ын Засгийн газрын дарга В.А.Зубков нар өргөтгөсөн хэлэлцээ хийж баримт бичигт гарын үсэг зурав. Ерөнхий сайд ОХУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Д.А.Медведев, Ерөнхийлөгч В.В.Путин нарт бараалхснаар албан ёсны айлчлалууд өндөрлөв.

Айлчлалын үеэр дараах баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:

1. Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр,

2. Мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд болон тэжээл экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх мал эмнэлэг, ариун цэврийн нөхцлийн болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын хил орчмын бүс нутагт хэрэгжүүлэх хамтарсан арга хэмжээний тухай Монгол Улсын ХХААЯ, Оросын Холбооны Улсын ХААЯ-ны хоорондын Протокол,

3. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2008-2011 онд хамтран ажиллах тухай хөтөлбөр,

4. Ураны хүдэр болон дагалдах ашигт малтмалыг эрж хайх, олборлох, боловсруулах салбарт олон улсын төсөл хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Үйлдвэр, худалдааны яам, Оросын Холбооны Улсын “Росатом” атомын энергийн улсын корпораци хоорондын хамтарсан арга хэмжээний төлөвлөгөө,

5. Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2006 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Холбооны аэронавигацийн алба хооронд хамтран ажиллах тухай Ажлын хэлэлцээр,

6. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай 1999-4-20-ны өдрийн гэрээ болон Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх , иргэний ба эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцааны тухай гэрээний нэмэлт Протоколын Батламж жуух бичиг солилцох тухай Протокол,

7. Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжил зүйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний төв, Оросын Холбооны Улсын Техникийн зохицуулалт, хэмжил зүйн Агентлаг хоорондын Санамж бичиг,

8. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны хооронд 2008 – 2009 онд хамтран ажиллах хөтөлбөр,

9. Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Оросын Холбооны Улсын Санкт-Петербургийн Хөдөө аж ахуйн их сургуулийн хооронд хамтран ажиллах Протокол,

10. Монголын агаарын тээврийн “МИАТ” компани болон Оросын “Аэрофлот – Российские авиалинии” нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

11. Монгол Улсын “Голомт” банк, ОХУ-ын “Оросын хөдөө аж ахуйн банк” нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр,

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Москва хотноо халуун дотно хүлээн авсанд талархал илэрхийлж, Оросын Холбооны Улсын Засгийн газрын дарга В.А.Зубковыг тааламжтай цагтаа Монгол Улсад айлчлахыг урив. Урилгыг талархан хүлээн авав.

**05.20** Бээжинд болсон ШХАБ-ын 3 дахь удаагийн Форумд ГХЯ-ны БТМҮГ-ын зөвлөх Ц.Батбаяр оролцож, “Монгол ба ШХАБ-ын хамтын ажиллагааны зарим асуудал” сэдвээр илтгэл тавив. Форумд гишүүн 6 ажиглагч 4 орны нийт 60 гаруй эксперт, дипломатууд оролцож ШХАБ-ын эдийн засаг, аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, ажиглагч орнуудтай хамтын ажиллагааг зузаатгах асуудлаар санал солилцов. ШХАБ нь Монгол Улсын хувьд Төв Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох чухал суваг бөгөөд манай улсын гадаад бодлого, гадаад эдийн засгийн харилцаанд чухал байр суурь эзэлдэг орнуудыг эгнээндээ багтаасан учраас Монгол Улс юуны өмнө ШХАБ-ын эдийн засгийн үйл ажиллагаа, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү оролцох сонирхолтой байдгаа илэрхийлэв.

**05.24** Гадаад хэргийн сайд С.Оюун БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр БНХАУ-ын дэд дарга Си Жинпин, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн Дай Бингуо нарт бараалхаж, БНХАУ-ын Гадаад хэргийн сайдтай хэлэлцээ хийж, Хятадын Дипломатын академи болон Төмөр замын яаманд зочилв. Уулзалт, яриа хэлэлцээний үеэр хоёр талын харилцааны байдалд үнэлэлт дүгнэлт өгч, дээд, өндөр хэмжээний айлчлал, уулзалтын давтамжийг хадгалах, 2009 онд тохиох хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой, найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсаны 15 жилийн ойг хамтран тэмдэглэх, хоёр орны ГХЯ-дын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны ерөнхий чиг хандлага, энэ салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, соёл боловсрол, батлан хамгаалах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хэлэлцэж, олон улс болон бүс нутгийн асуудлаар санал бодлоо солилцов.

**06.19** БНХАУ-ын дэд дарга Си Жиньпин Монгол Улсын Засгийн газрын урилгаар албан ёсны айлчлал хийв. Хятадын Гадаад худалдааг дэмжих хорооны дарга Ван Жи Фэй тэргүүтэй БНХАУ-д төдийгүй дэлхий дахинд нэр хүндтэй 150 гаруй бизнес эрхлэгч, Хятад, Хонгконг, Макаогийн 100 орчим сурвалжлагч иржээ. Хятадын нэр хүндтэй бизнесмэнүүд дэд даргынхаа айлчлалын хүрээнд Монгол-Хятадын бизнес форум зохион байгуулав. Ноён Си Жиньпин Ерөнхий сайд С.Баяртай уулзалт, албан ёсны хэлэлцээ хийж, Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны болон яам хоорондын харилцааны 10 гаруй баримт бичигт гарын үсэг зурав. Түүнчлэн тэрбээр сүүлийн жилүүдэд хоёр орны хооронд өндөр дээд хэмжээний айлчлалууд тогтмолжиж, худалдаа эдийн засгийн харилцаа ихээхэн нэмэгдэн, гадаад худалдааны бараа эргэлт 2007 онд 2.0 тэрбум гаруй ам.долларт хүрсэнд сэтгэл нэн ханамжтай байгаагаа илэрхийлэв. Ерөнхий сайд С.Баяр “Хамтын ажиллагааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нь хоёр орны ард түмний эрх ашигт бүрнээ нийцнэ. Манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсны 15 жилийн ойн хүрээнд таны тавьсан саналын дагуу иргэд хоорондын харилцааг хөгжүүлэхийг

бид чухалчлах болно” гэв. Тэрбээр газрын тосны олборлолт, боловсруулалт, гуравдагч орноос авахаар төлөвлөж буй газрын тосыг Хятадаар дамжуулан импортлох, боловсруулах үйлдвэртэй болох санаачилгад БНХАУ-ын Засгийн газар дэмжлэг тусалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байна гэлээ. Түүнчлэн БНХАУ-аас манай улсад олгосон 300 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгийг ашиглах салбар, чиглэлийг шинэчлэн тогтоох талаар хоёр тал тохиролцоонд хүрч буйг сайшаагаад шинээр олгож буй 40 сая юанийн тусламжийг үр ашигтай зарцуулахад анхаарна гэдгээ илэрхийлэв. Уулзалтын үеэр авто болон төмөр замын сүлжээг өргөтгөх, хилийн боомтууд дахь мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, соёлын харилцааг өргөжүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хоорондын харилцаа гүнзгийрүүлэх, харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, шинэчлэх, гадаад харилцаанд харилцан бие биенийг дэмжих зэрэг олон асуудлуудыг хөндөж ярилцав.

**07.24** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Кувейт улсын Эмир шейх Сабах Аль-Ахмед Аль-Жабер Аль-Сабах 7 сарын 23-наас 8 сарын 2-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийв. Кувейтын Ерөнхий сайд Шейх Насер Аль-Мохамед Аль-Ахмед Аль-Сабах, Парламентын дарга Жасем Мохамед Аль-Хорафи, Кувейтын Эрчим хүч, усны сайд, Газрын тосны сайдын үүрэг гүйцэтгэгч Мохамед Аль-Алейм, Кувейтын сангийн дэд захирал Ганим Сулейман Аль-Гинейман нар Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхав. Ерөнхийлөгч Кувейтын шинжлэх ухаан, технологийн хүрээлэн, Судалгааны төв лабораторийн үйл ажиллагаатай нь танилцаж, Монгол, Кувейтын бизнес эрхлэгчдийн уулзалтад оролцож үг хэлэв. Айлчлалын үеэр Кувейтын буцалтгүй тусламжаар Үндэсний номын сан бариулах, Мянганы замд санхүүжилт авах, түүхий газрын тос импортлоход тодорхой квот олгох асуудлыг ярилцав. Кувейтийн тал нааштай хандаж урьдчилсан байдлаар хүлээн авав. Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах төвийг Монголд байгуулах талаар тохиролцов. Айлчлалын үеэр Кувейт улстай нэг хөтөлбөр, хоёр санамж бичиг байгуулав.

**08.02** Бүгд Найрамдах Хорват Улсын Ерөнхийлөгч Степан Месич Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Монгол Улсад айлчлав. Энэхүү айлчлал нь Монгол Улс, Бүгд Найрамдах Хорват Улсын хооронд дипломат харилцаа тогтоосон цагаас хойш Хорватын талаас хэрэгжүүлж буй төрийн дээд хэмжээний анхны айлчлал юм. Ерөнхийлөгч С.Месич айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяртай хэлэлцээ хийж, УИХ-ын дарга Д.Лүндээжанцан, Ерөнхий сайд С.Баяр нартай уулзсан аж. Хорватын ерөнхийлөгчийг хөл тавихаас өмнө анх тус улсын Гадаад хэргийн яамны туслах сайд /assistant minister/ Вера Тадич тэргүүтэй төлөөлөгчид 1998 оны дөрөвдүгээр сард Монгол Улсад ажлын айлчлал хийж байсан. Үүний дараа 2002 онд Монгол, Хорват улсын Ерөнхийлөгч нар нүүр тулан уулзаж байсан байна. Хоёр орны төрийн тэргүүнүүд Швейцарьт болсон Гранд-Монтанагийн чуулга уулзалтын үеэр уулзаж, харилцаа, хамтын ажиллагааны

асуудлаар санал солилцож байв. Энэ удаа тус улсын төрийн тэргүүн Монголд ирж хоёр орны харилцаагаа батжууллаа.

**08.07** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев айлчлав. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монголын төрийн хүндэт Эрдэнийн-Очир хэмээх одонгоор Н.Назарбаевыг шагнасанд Казахстаны ерөнхийлөгч ихэд баярлаж байгаагаа илэрхийлэв. Хоёр орны ерөнхийлөгч нар уулзалт, хэлэлцээ хийсний дараа хамтран ажиллах баримт бичгүүдийг үзэглэв. Мөн энэ үеэр боловсролын салбарт хамтран ажиллах гэрээнд БСШУ-ны сайд Н.Болормаа, нийгмийн хамгааллын салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх баримт бичигт НХХ-ийн сайд Д.Дэмбэрэл, 2008-2012 онд хамтран ажиллах санамж бичигт ГХ-ийн сайд С.Оюун, Казахстаны Гадаад хэргийн сайд болон Хүн ам, хөдөлмөрийн яамны сайд нар гарын үсэг зурав. “Казахстан, Монголын дипломат харилцаа тогтоосны 15 жилийн ой энэ жил тохиож байхад Н.Назарбаев ерөнхийлөгчийг айлчилж байгаад ихэд бэлгэшээж байна” гэж Монголын төрийн тэргүүн онцолж байв. Монголд 1-1,5 сая тонн түүхий нефтийг нийлүүлэх хүсэлтийг Монголын талаас уламжлахад нааштайгаар хүлээн авч дэмжихээ Н.Назарбаев мэдэгдэв. Мөн түүнчлэн 20-30 мянган тонн улаан буудайг буцалтгүй тусламжаар нийлүүлэх асуудлыг сайтар судлан шийдвэрлэхээ ч амалсан байна. Казахстан нь нүүрс ус, металл, уран, үр тарианы баялаг нөөцтэйгээс гадна олборлолт, ашиглалтаараа дэлхийд тэргүүлэх бүрэн бололцоотой орон. Манай хоёр орон байгалийн баялаг ихтэйгээрээ төстэй ч тус улс Монголын уул уурхай, банк санхүүгийн салбарыг түлхүү сонирхож хөрөнгө оруулах бололцоотойгоо айлчлалын үеэр уламжилж байлаа.

**08.12** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Шинэ Зеландын амбан захирагч Ананд Сатиананд манай улсад айлчлав. Манай улс нь Шинэ Зеланд улстай дипломат харилцаа тогтоогоод 33 жил болж байгаа хэдий ч амбан захирагч нь анх удаа зочлов. Тус улсын Засгийн газар 1991-2002 оны хооронд манай улсад 1.828.854 ам. долларын тусламж үзүүлж байжээ. Энэхүү тусламжийг “Төрийн захиргааны шинэтгэлийн хөтөлбөр”, “Ядуурлыг бууруулах сан”, “Англи хэлний сургалт” гэсэн төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулаад дуусгасан байна. Мөн түүнчлэн жил бүр Монголын нэг төрийн албан хаагчийг хэлний зургаан сарын сургалтад төлбөргүй хамруулдаг аж.

**08.20** Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Данийн угсаа залгамжлах хан хүү Фредерик манай улсад айлчлав. Тэрбээр Монгол Улсын төрийн тэргүүн, Ерөнхий сайдад бараалхсаны дараа Монгол-Данийн нийгэмлэгт зочилсон юм. Айлчлалын үеэр Ханхүү Фредерик-д МУБИС-ийн хүндэт доктор цолыг олгожээ. Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиож байгаа учир хамтарсан бизнесийн уулзалт зохион байгуулсав.

**08.22** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Монакогийн Эрхэм дээд Хан Хоёрдугаар Альберт Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Монакогийн Хан Хоёрдугаар Альбертыг Монгол Улсын

Ерөнхийлөгч Н.Энхбаяр хүлээн авч уулзав. Монакогийн Хан Архангай аймгийн нутагт явагдаж буй Монгол, Монакогийн хамтарсан археологийн судалгааны ажилтай танилцав.

**08.22** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр БНХАУ-ын төр, засгийн тэргүүнүүдтэй уулзаж, Зуны олимпийн ХХИХ их наадмын хаалтын ёслолд оролцохоор Бээжин хотод хүрэлцэн ирсэн юм. Ноён Ху Жинтао, Вэнь Зябао, Си Жиньпин нар Монгол Улсын Засгийн газар, Монголын ард түмэн “Бээжин-2008”-ыг дэмжиж байгаад талархаж байгаагаа илэрхийлээд Монголын тамирчид Олимпод амжилттай оролцож байгаад баяр хүргэлээ. Ерөнхий сайд С.Баяр уулзалтуудын үеэр “Бээжин-2008” олимп монголчуудад ээлтэй наадам болж буйг дурдаад Олимпийн шилдэг наадмыг өндөр хэмжээнд зохион байгуулж буй БНХАУ-ын Засгийн газар, ард түмэнд баяр хүргэв. Дээрх уулзалтуудаар хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлвийн талаарх асуудлыг хөндөж ярилцлаа. Ерөнхий сайд С.Баяр БНХАУ-аас нефтийн бүтээгдэхүүн импортлох, гуравдагч орноос, тухайлбал Казахстанас авахаар тохирсон түүхий газрын тосыг БНХАУ-д боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн авах, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн том оврын дулааны цахилгаан станц барих, эрчим хүч экспортлох төслийг эрчимжүүлж, үр дүнд хүргэх зэрэг асуудлыг хөндөж, энэ чиглэлийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулна уу хэмээн хүсэв. Тэрбээр БНХАУ-ын дэд дарга Си Жиньпиний зургадугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалын дараа хамтын ажиллагааны тодорхой асуудлууд үр дүнд хүрч, эрчимжиж байгааг онцлон тэмдэглэв.

**09.05** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай улсад айлчилж байгаа ХБНГУ-ын Ерөнхийлөгч Хорст Көлер-т бараалхав. “Холбооны Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийж буй айлчлал нь Монгол, Германы ойр дотно харилцаа, хамтын ажиллагааны илэрхийлэл болж байна. Түүнчлэн манай орны улс төрийн амьдралын нэлээд онцлог үетэй Таны айлчлал давхцаж байна” хэмээн уулзалтын эхэнд Ерөнхий сайд онцоллоо. Ноён Ерөнхийлөгч Хорст Көлер элгэсэг дотноор угтан зочилж байгаад нь Монгол Улсын Ерөнхий сайдад талархав. Ерөнхий сайд С.Баяр Монгол Улсад сонгуулийн дараа үүссэн улс төрийн нөхцөл байдал, сонгуульд олонхийн суудал авсан МАХН-аас Эвслийн Засгийн газар байгуулах талаар гаргасан шийдвэрийн талаар товч мэдээлэв.

**09.27** АНУ-д Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мунтай уулзав. Уулзалтын үеэр НҮБ-ын үйл ажиллагааны шинэчлэл, Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд Монгол Улсаас хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ зэрэг асуудлуудыг хөндөж ярилцав. Ерөнхий сайд С.Баяр НҮБ-ын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд Монгол Улс цаашид ч оролцоход бэлэн байгааг нотолсны гадна Улаанбаатарын ойролцоох Тавантолгойн цэргийн сургалтын төвийг бүс нутгийн хэмжээнийх болгох талаар хамтран хүчин чармайлт тавих нь зүйтэй гэдэгт хоёр тал санал нэгтэй байгаагаа нотлов. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын тэргүүн НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын



газрын өндөр, томоохон хэмжээний албан тушаалд Монгол хүмүүсийг ажиллуулах талаар Ерөнхий нарийн бичгийн даргад санал тавьсан юм. Бан Ги Мун БНСУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байхдаа Монгол Улсад айлчилж байсан бөгөөд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын хувиар Монгол Улсад айлчилна уу гэсэн Ерөнхий сайд С.Баярын урилгыг талархан хүлээж авав.

**10.07** Бүгд Найрамдах Турк Улсын Шадар сайд бөгөөд Төрийн сайд Хаяати Языжы Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярт бараалхав. Туркийн Ерөнхий сайд Рэжэп Тайип Эрдоан энэ сарын 5-ны өдрөөс Монгол Улсад албан ёсоор айлчлах байсан боловч нутагт нь онцгой байдал үүссэний улмаас айлчлалаа хойшлуулан, ирэх замаасаа буцсан тул эрхэмсэг ноён Хаяати Языжы манай улсад айлчилсан билээ. Туркийн салан тусгаарлагч курдууд тус улсын хилийн цэргүүдийн эсрэг зэвсэгт халдлага үйлдэж, хүний амь нас эрсэдсэнд харамсч байгаагаа Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр уулзалтын эхэнд илэрхийлээд Тэрбээр хоёр орны харилцаа улс төр, худалдаа, эдийн засаг, соёл боловсрол гээд бүхий л салбарт амжилттай өрнөн хөгжиж буйг онцлоод цаашид улам гүнзгийрүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаагаа тэмдэглэв. Ноён Шадар сайд Хаяати Языжыг “Ирэх жил тохиох Монгол, Туркийн хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг угтаж, тодорхой ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд энэ талаар хоёр улсын Гадаад харилцааны яамд бэлтгэл ажилдаа ороод байгаа. Мөн 2009 онд өндөр дээд хэмжээний харилцан айлчлалыг зохион байгуулах нь зүйтэй гэж бид үзэж байна. Түүнчлэн “ТИКА”-гийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, тусламжийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх байр суурийг Турк улсын Засгийн газар баримталж байгаа” гэлээ. Ирэх жил болох НҮБ-ын Ерөнхий Ассамблейн байнгын бус гишүүний сонгуульд Монгол Улс Туркийг дэмжинэ гэдэгт итгэж байгаагаа Шадар сайд илэрхийлсэн юм.

**10.09** Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр Японы Эдийн засаг, үйлдвэр, худалдааны дэд сайд Х.Ишигэ-г хүлээн авч уулзав. Тэрбээр Улаанбаатарт болж буй Монгол, Японы Засгийн газар, хувийн хэвшлийнхний хоёрдугаар зөвлөлдөх уулзалтад оролцсон буй юм. Ноён Х.Ишигэ Зөвлөлдөх уулзалтад Японы яамдаас гадна “Иточү”, “Мицубиши”, “Марубени” зэрэг компани, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, зарим судалгааны хүрээлэнгүүдийн 50 орчим хүн оролцож байна гээд хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, Японы хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр бодит ажил хэрэг өрнүүлэх нь чухал гэж үзэж байгаагаа тэмдэглэв. Түүнчлэн Японы хувийн хэвшлийнхэн Монгол Улсын ашигт малтмалын салбарт, тухайлбал уран, зэс, нүүрс, газрын ховор металлын олборлолтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой байгаа тул Монгол Улсын Засгийн газраас тодорхой дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв. Ерөнхий сайд С.Баяр хоёр дахь удаагаа зохиогдож байгаа Зөвлөлдөх уулзалтад Японы тал ихээхэн ач холбогдол өгч байгаад бид баяртай байна гээд энэ удаагийн Зөвлөлдөх уулзалт Монгол Улсын шинэ Засгийн газрын хөгжлийн бодлого,

үйл ажиллагааг Японы Засгийн газар, хувийн хэвшлийнхэнд танилцуулах өргөн боломжийг олгож байна гэв. Тэрбээр Япон улсаас манай улсад үзүүлсээр ирсэн тусламж дэмжлэгт манай ард түмэн ихээхэн талархалтай ханддаг бөгөөд харилцаа, хамтын ажиллагааг цаашид өрнүүлэх чин эрмэлзэлтэй байгааг тэмдэглэлээ.

**10.20** Швейцарийн Холбооны Улсын Парламентын ерөнхийлөгч эрхэмсэг ноён Андре Буньон Монгол Улсын Их Хурлын дарга Д. Дэмбэрэлийн урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. УИХ-ын дарга Д.Дэмбэрэл ШХУ-ын Парламентын ерөнхийлөгч А.Буньоны Монгол Улсад хийж буй энэхүү албан ёсны айлчлал нь ШХУ болон Монгол Улсын хооронд 1964 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Швейцарийн талаас парламентын түвшинд хийж буй анхны айлчлал болж буйг онцлон тэмдэглэсэн юм. Мөн хоёр орны харилцаа сүүлийн жилүүдэд улам эрчимтэй хөгжиж, ШХУ-аас Монгол Улсад хэрэгжүүлэх хүмүүнлэгийн болон хөгжлийн хамтын ажиллагаа амжилттай явагдаж, ШХУ-аас жил бүр 9 сая швейцарь франк буюу 9 тэрбум төгрөгийн тусламж үзүүлж байгаад нэн талархаж байгаагаа илэрхийлсэн юм. Айлчлалын үеэр тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхаж, хоёр орны харилцааны цаашдын төлөвийн талаар ярилцав. Швейцарийн хөгжлийн агентлагаас Монгол Улсад цөлжилттэй тэмцэх асуудлаар дэмжлэг үзүүлж байгаад Ерөнхийлөгч талархаад, цаашид ч мөн дэмжиж ажиллана гэдэгт итгэж байгаа илэрхийллээ.

**10.29** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар БНСВУ-ын ерөнхийлөгч Нгуен Минь Чиет гэргийн хамт айлчлав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр ерөнхийлөгч Нгуен Минь Чиетийн айлчлал нь хоёр орны харилцаанд чухал алхам болж байгааг тэмдэглээд яриа хэлэлцээний үр дүнг ажил хэрэг болгохын төлөө байгаагаа илэрхийлэн, хоёр улсын улс төрийн харилцааны өнөөгийн байдалд сэтгэл ханамжтай, өндөр түвшний уулзалт айлчлал тогтмолжиж байгаа ч эдийн засгийн хамтын ажиллагаагаа боломж нөхцөлтөйгөө харьцуулбал доогуур түвшинд байгааг анхааран засгийн газар хоорондын комиссын ажлыг тодорхой хөтөлбөр чиглэлийн дагуу эрчимжүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэв.

**10.30** Цог жавхланта хатан хааны хүү Иоркийн гүн хунтайж Эндрю Монгол Улсын ерөнхийлөгч ГХ-ны сайд болон батлан хамгаалахын сайд нартай тус тус уулзав. Цог жавхланта хатан хааны хүү Иоркийн гүн хунтайж Эндрю нь манай хоёр орны халуун дотно харилцааг онцлох, мөн дэлхий дахины энхийг сахиулах үйл ажиллагаанд МУ-ын оруулж буй дорвитой хувь нэмрийг үнэлж байв. Иоркийн гүн Эндрю нь Их Британы олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын тусгай төлөөлөгчийн хувиар өөрийн орны байгаль орчны ээлтэй технологигоор дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулан энэ талын Монгол улсад тулгараад байгаа, байгаль орчны асуудлуудыг шийдэхэд хэрхэн тусалж чадах талаар судлахыг хүсэв

**11.10** ОХУ-ын Ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгч, Монгол Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.В.Гордеевийн урилгаар зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд Х.Баттулга ОХУ-д

айлчлав. Москва хотноо хийсэн ажлын айлчлалын үеэр ноён А.В.Гордеев тээврийн сайд И.Е.Левитин болон Оросын Төмөр зам нээлттэй нийгэмлэгийн Ерөнхийлөгч В.И.Якунин нартай уулзаж хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Хоёр орны зам, тээвэр барилгын салбар, ялангуяа хамтарсан засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй 100 мянган айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөц боломжийн тухайд ноён Гордеевтэй уулзах үеэрээ ярилцсан байна.

**12.19** УИХ-ын дарга Дэмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид БНАЛАУ-ын Ерөнхийлөгч эрхэмсэг ноён Чуммали Саясонд бараалхав. УИХ-ын дарга Д.Дэмбэрэл Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын мэндчилгээг түүнд уламжлаад БНАЛАУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлал энэ үеэр ярьж тохиролцсон асуудлууд үр дүнтэй биелж байгааг онцлон тэмдэглэв. Цаашид 2 орны харилцаа, түүний дотор парламентын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх сайхан боломж байна. Энэ хүрээнд ирэх жил БНАЛАУ-ын Хөдөө аж ахуйн сайдыг Монгол Улсад айлчилна гэдэгт найдаж байна гэв. Мөн Вьентьян болон Улаанбаатар хот хамтран ажиллах боломж бий гэж үзэв.

*Бэлтгэсэн Б.Мандхай (ОУСХ-ийн эрдэм  
шинжилгээний ажилтан)*